



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

2017 оны 07 дугаар сарын 21
№27 /984/

**Монгол Улсын
хууль**

**Эх, олон хүүхэдтэй
өрх толгойлсон эх, эцэгт
тэтгэмж олгох тухай**

**Монгол Улсын
хууль**

**Монгол Улсын
Ерөнхийлөгчөөр сонгогдсон
гэж үзэж бүрэн эрхийг нь
хүлээн зөвшөөрөх тухай**

**Монгол Улсын
Их Хурлын
тогтоол**

**Монгол Улсын Их Хурлын
2017 оны намрын ээлжит
чуулганаар хэлэлцэх
асуудлын тухай**

ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

450.	Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай		1750
451.	Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай		1753
452.	Төв Азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны институтийг үүсгэн байгуулах тухай хэлэлцээрийг соёрхон батлах тухай		1754
453.	Зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай		1754
454.	Зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай		1754
455.	Монгол Улсын Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэж бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрөх тухай		1755

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

456.	Монгол Улсын Их Хурлын 2017 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай	Дугаар 49	1755
457.	Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Дугаар 50	1757
458.	Монгол Улсын 2016 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай	Дугаар 51	1759
459.	Монгол Улсын 2016 оны төсвийн гүйцэтгэл баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай	Дугаар 52	1759
460.	Монгол Улсын Ерөнхийлөгчийн тангараг өргөх тов тогтоох тухай	Дугаар 54	1760

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**2017 оны 06 дугаар
сарын 30-ны өдөрУлаанбаатар
хот**ЭХ, ОЛОН ХҮҮХЭДТЭЙ ӨРХ ТОЛГОЙЛСОН
ЭХ, ЭЦЭГТ ТЭТГЭМЖ ОЛГОХ ТУХАЙ****НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ****1 дүгээр зүйл.Хуулийн зорилт**

1.1.Энэ хуулийн зорилт нь жирэмсэн эх, 0-3 хүртэлх насны хүүхдээ асарч байгаа эх, дөрөв хүртэлх насны ихэр хүүхэдтэй эх, эцэг, гурав болон түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

**2 дугаар зүйл.Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх,
эцэгт тэтгэмж олгох хууль тогтоомж**

2.1.Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль¹, Нийгмийн халамжийн тухай хууль², Гэр бүлийн тухай хууль³, Хөдөлмөрийн тухай хууль⁴, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль⁵, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1.“асран хамгаалагч, харгалзан дэмжигч” гэж Гэр бүлийн тухай хуулийн 67.1.1-д заасны дагуу хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр тогтоогдсон хүнийг;

3.1.2.“хүүхэд үрчлэн авах” гэж Гэр бүлийн тухай хуулийн 55 дугаар зүйлд заасны дагуу хүүхэд үрчлэн авахыг;

¹Монгол Улсын Үндсэн хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

²Нийгмийн халамжийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2012 оны 8 дугаарт нийтлэгдсэн.

³Гэр бүлийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1999 оны 30 дугаарт нийтлэгдсэн.

⁴Хөдөлмөрийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1999 оны 25 дугаарт нийтлэгдсэн.

⁵Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2011 оны 40 дугаарт нийтлэгдсэн.



3.1.3. “хүүхдээ асарч байгаа” гэж Хөдөлмөрийн тухай хуулийн 106.1-д заасан хүүхэд асрах чөлөөтэй болон Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 3.1.3-т заасан ажилгүй эх 0-3 хүртэлх насны хүүхдээ асарч байгааг;

3.1.4. “өрх толгойлсон эх, эцэг” гэж Нийгмийн халамжийн тухай хуулийн 3.1.8-д заасан хүнийг.

4 дүгээр зүйл.Хуулийн хамрах хүрээ

4.1.Энэ хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан болзол, шалгуур, нөхцөлийг хангасан Монгол Улсын иргэн, Монгол Улсад хууль ёсоор байнга оршин суудаг гадаадын иргэн, харьяалалгүй хүн хамрагдана.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ТЭТГЭМЖИЙН ТӨРӨЛ

5 дугаар зүйл.Тэтгэмжийн төрөл

5.1.Төрөөс олгох тэтгэмж дараахь төрөлтэй байна:

5.1.1.жирэмсэн эхийн тэтгэмж;

5.1.2.0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмж;

5.1.3.ихэр хүүхдийн тэтгэмж;

5.1.4.гурав болон түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмж.

6 дугаар зүйл.Тэтгэмж авах эрх

6.1.Жирэмсний таван сартайгаас эхлэн хүүхэд төрүүлэх хүртэлх хугацаанд эх сар бүр тэтгэмж авах эрхтэй.

6.2.Төрүүлсэн 0-3 хүртэлх насны хүүхдээ асарч байгаа эх сар бүр хүүхэд асарсны тэтгэмж авах эрхтэй.

6.3.Дөрөв хүртэлх насны ихэр хүүхэд төрүүлсэн эх нэг удаа тэтгэмж авах эрхтэй.

6.4.0-18 хүртэлх насны гурав болон түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэг улирал бүр тэтгэмж авах эрхтэй бөгөөд хүүхдийн тоонд төрүүлсэн болон үрчлэн авсан, асран хамгаалж, харгалзан дэмжиж байгаа хүүхдийг хамааруулна.



7 дугаар зүйл.Тэтгэмж олгохтой холбогдсон харилцаа

7.1.Энэ хуулийн 5.1.1, 5.1.2, 5.1.3-т заасан тэтгэмжийн хэмжээг Засгийн газар тогтооно.

7.2.Энэ хуулийн 5.1.4-т заасан тэтгэмжийн хэмжээ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцүү байна.

7.3.Энэ хуулийн 5.1-д заасан тэтгэмж олгох журмыг Засгийн газар батлах бөгөөд тэтгэмжид зарцуулах хөрөнгийг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

7.4.Энэ хуулийн 5.1.2, 5.1.3, 5.1.4-т заасан тэтгэмж авах эх нас барсан, эсхүл тэжээн тэтгэхээс зайлсхийсэн тохиолдолд тэтгэмжийг хүүхдийн эцэг, эсхүл хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигч, үрчлэн авсан эх, эцэгт олгоно.

7.5.Банк, санхүүгийн байгууллага энэ хуулийн 5.1-д заасан тэтгэмжийг барьцаалан зээл олгохыг хориглоно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

8 дугаар зүйл.Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

8.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтанд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол Төрийн албаны тухай хуульд⁶ заасан хариуцлага хүлээлгэнэ.

8.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль⁷, эсхүл Зөрчлийн тухай хуульд⁸ заасан хариуцлага хүлээлгэнэ.

9 дүгээр зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

9.1.Энэ хуулийг 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

⁶Төрийн албаны тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2002 оны 28 дугаарт нийтлэгдсэн.

⁷Эрүүгийн хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2016 оны 07 дугаарт нийтлэгдсэн.

⁸Зөрчлийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2017 оны 24 дугаарт нийтлэгдсэн.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 06 дугаар
сарын 30-ны өдөр

Улаанбаатар
хот

НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нийгмийн халамжийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараахь заалт нэмсүгэй:

1/18 дугаар зүйлийн 18.2.12 дахь заалт: -

“18.2.12.гурав болон түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн хүүхэд.”

2/20 дугаар зүйлийн 20.2.7 дахь заалт:

“20.2.7.энэ хуулийн 3.1.11-д заасан босго шугамаас доогуур амьжиргаатай өрх толгойлсон эх, эцгийн хүүхэд.”

2 дугаар зүйл. Нийгмийн халамжийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6 дахь хэсгийн “13.5.5-д” гэснийг “13.5.4-д” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Нийгмийн халамжийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6 дахь хэсгийн “13.5.8,” гэснийг хассугай.

4 дүгээр зүйл. Нийгмийн халамжийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4, 13.5.5, 13.5.8 дахь заалт, 13.7, 13.8 дахь хэсгийг тус тус хүчингүй болгосугай.

5 дугаар зүйл. Энэ хуулийг Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 07 дугаар
сарын 06-ны өдөр

Улаанбаатар
хот

**ТӨВ АЗИЙН БҮС НУТГИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ХАМТЫН
АЖИЛЛАГААНЫ ИНСТИТУТИЙГ ҮҮСГЭН БАЙГУУЛАХ
ТУХАЙ ХЭЛЭЛЦЭЭРИЙГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Төв Азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны институтийг үүсгэн байгуулах тухай хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 07 дугаар
сарын 06-ны өдөр

Улаанбаатар
хот

**ЗЭЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН
БАТЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банк хооронд байгуулсан “Нийгмийн халамжийг дэмжих хөтөлбөр-2”-ийн Зээлийн хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 07 дугаар
сарын 06-ны өдөр

Улаанбаатар
хот

**ЗЭЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН
БАТЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банк хооронд байгуулсан “Банкны салбарыг нөхөн сэргээх, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх хөтөлбөр”-ийн Зээлийн хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 07 дугаар
сарын 10-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧӨӨР СОНГОГДСОН ГЭЖ ҮЗЭЖ БҮРЭН ЭРХИЙГ НЬ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Гучин нэгдүгээр зүйлийн 5 дахь хэсэг, Сонгуулийн тухай хуулийн 147 дугаар зүйлийн 147.2 дахь хэсэгт заасныг үндэслэн Халтмаагийн Баттулгыг Монгол Улсын Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэж бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2017 оны 07 дугаар
сарын 06-ны өдөр

Дугаар 49

Улаанбаатар
хот

Монгол Улсын Их Хурлын 2017 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын 2017 оны намрын ээлжит чуулганаар дараахь асуудлыг хэлэлцэхээр төлөвлөсүгэй:

1/Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуулийн төсөл;
2/Нийгмийн даатгалын сангийн 2018 оны төсвийн тухай хуулийн төсөл;

3/“Төрөөс мөнгөний бодлогын талаар 2018 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

4/Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл;

5/Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулга болон Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төсөл;



6/Хөрөнгө оруулалтын банкны тухай хуулийн төсөл;
7/Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;

8/Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;

9/Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;

10/Багшийн хөгжлийн тухай хуулийн төсөл;
11/Донорын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;
12/Баяжуулсан хүнсний тухай хуулийн төсөл;
13/Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;

14/Стандартчилал, техникийн зохицуулалт, итгэмжлэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;

15/Төв банк /Монголбанк/-ны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

16/Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

17/бусад.

2.Хэлэлцүүлгийн шатанд байгаа болон Монгол Улсын Ерөнхийлөгч, Монгол Улсын Их Хурлын гишүүд, Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн энэ тогтоолын 1-д зааснаас бусад хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслүүдийг Монгол Улсын Их Хурлын 2017 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцүүлэх асуудлыг тухай бүрд шийдвэрлэж байхаар тогтоосугай.

3.Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг хууль санаачлагчаас өргөн мэдүүлбэл намрын ээлжит чуулганы хэлэлцэх асуудлын дараалалд оруулахыг Улсын Их Хурлын даргад зөвшөөрсүгэй.

4.Монгол Улсын Их Хурлын 2017 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын бэлтгэл хангахыг Монгол Улсын Их Хурлын Байнгын хороод, Монгол Улсын Их Хурал дахь намын бүлгүүд, Монгол Улсын



Засгийн газар /Ж.Эрдэнэбат/, Монгол Улсын Их Хурлын Тамгын газар /Ц.Цолмон-т тус тус үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2017 оны 07 дугаар
сарын 06-ны өдөр

Дугаар 50

Улаанбаатар
хот

**Тогтоолын хавсралтад нэмэлт,
өөрчлөлт оруулах тухай**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын 1993 оны 6 дугаар сарын 08-ны өдрийн 40 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын Ерөнхийлөгч тангараг өргөх ёслолын журам”-д доор дурдсан агуулгатай дараахь заалт нэмсүгэй:

1/Хоёрын 9 дэх заалт:

“9.Бүрэн эрх нь дуусгавар болсон Ерөнхийлөгч шинэ сонгогдсон Ерөнхийлөгч тангараг өргөсний дараа Төрийн тамгыг хадаг /нанжвандан/ дээр залж, шинэ Ерөнхийлөгчид хүндэтгэлтэйгээр өргөн барина. Шинэ Ерөнхийлөгч Төрийн тамгыг хүндэтгэлтэйгээр гардан авч, адислан ширээн дээрээ зална.”

2.“Монгол Улсын Ерөнхийлөгч тангараг өргөх ёслолын журам”-ын дараахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/Нэгийн 1 дэх заалт:

“1.Төрийн ордны Их танхимын тайзны гүнд хөх цэнхэр дэвсгэр дээр Монгол Улсын Төрийн сүлд залж, түүний дэргэд баруун гар талд Монгол Улсын төрийн далбааг байрлуулсан байна. Төрийн далбааны дэргэд ам дөрвөлжин цагаан эсгий дэвсэж, хоёр талд Монгол Улсын төрийн ёслолын хүндэт харуулын цэрэг зогссон байна.

Их танхимын тайзны баруун гар талд шинээр сонгогдсон Ерөнхийлөгч, бүрэн эрх нь дуусгавар болж байгаа Ерөнхийлөгч болон Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргад зориулсан ширээ, сандал, Их танхимын тайзны зүүн гар талд Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд



болон Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргад зориулсан ширээ, сандал, Их танхимын тайзны голд шинээр сонгогдсон Ерөнхийлөгч тангараг өргөж, үг хэлэх индэр, тайзны зүүн, баруун жигүүрт Улсын Их Хурлын гишүүдийн суух сандлыг хивсэн дээр тус тус байрлуулсан байна.”

2/Хоёрын 7 дахь заалт:

“7.Ийнхүү зарламагц Ерөнхийлөгч Тамгын газрын даргыг, шинээр сонгогдсон Ерөнхийлөгч Төрийн ёслолын албаны даргыг дагуулан Их танхимын тайзнаа хүрэлцэн ирж, журмын Нэгийн 1 дэх заалтад заасан ширээний ард зогсоно. Бүрэн эрхийн хугацаа дуусгавар болж байгаа Ерөнхийлөгч ийнхүү хүрэлцэн ирэхдээ Төрийн тамгыг залж авчран ширээн дээр тавина. Бүрэн эрхийн хугацаа дуусгавар болж байгаа Ерөнхийлөгч, шинэ сонгогдсон Ерөнхийлөгч монгол үндэсний хувцастай байна.

Ерөнхийлөгч тангараг өргөх ёслолын ажиллагааны үед Төрийн тамгыг хамгаалах үүргийг Төрийн ёслолын хүндэт харуулын дарга гүйцэтгэнэ.”

3.“Монгол Улсын Ерөнхийлөгч тангараг өргөх ёслолын журам”-ын Нэгийн 2 дахь заалтын “Их эзэн Чингис хааны хөшөөний өмнөх талбайн” гэснийг “Их танхимын тайзны” гэж, Нэгийн 4 дэх заалтын “Төрийн ордон цогцолборын өмнө, тусгай зассан талбайд” гэснийг “Их танхимд” гэж, Хоёрын 11 дэх заалтын “16 дахь” гэснийг “9 дэх” гэж, Хоёрын 12 дахь заалтын “Их эзэн Чингис хааны хөшөөний өмнө” гэснийг “Их танхимын тайзнаа” гэж, Хоёрын 13 дахь заалтын “ширээндээ залармагц” гэснийг “Төрийн тамгыг ширээн дээрээ залмагц” гэж, Хоёрын 18 дахь заалтын дугаарыг “16” гэж тус тус өөрчилсүгэй.

4.“Монгол Улсын Ерөнхийлөгч тангараг өргөх ёслолын журам”-ын Хоёрын 8 дахь заалтын “Их эзэн Чингис хааны хөшөөнд хүндэтгэл үзүүлээд,” гэснийг хассугай.

5.“Монгол Улсын Ерөнхийлөгч тангараг өргөх ёслолын журам”-ын Хоёрын 16, 17 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцугай.

6.Энэ тогтоолыг 2017 оны 07 дугаар сарын 06-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2017 оны 07 дугаар
сарын 06-ны өдөр

Дугаар 51

Улаанбаатар
хот

Монгол Улсын 2016 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.6 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10.4 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын 2016 оны төсвийн гүйцэтгэлийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээг 3,894,443.3 сая /гурван их наяд найман зуун ерэн дөрвөн тэрбум дөрвөн зуун дөчин гурван сая гурван зуун мянган/ төгрөгөөр баталсугай.

2.Монгол Улсын 2016 оны төсвийн гүйцэтгэлийн зарлагын /тэнцвэржүүлсэн орлогод нийцүүлсэн/ хэмжээг 7,394,235.5 сая /долоон их наяд гурван зуун ерэн дөрвөн тэрбум хоёр зуун гучин таван сая таван зуун мянган/ төгрөгөөр баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2017 оны 07 дугаар
сарын 06-ны өдөр

Дугаар 52

Улаанбаатар
хот

Монгол Улсын 2016 оны төсвийн гүйцэтгэл баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.7 дахь хэсэг, 36¹ дүгээр зүйлийн 36^{1.2} дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын 2016 оны төсвийн гүйцэтгэл баталсантай холбогдуулан дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Ж.Эрдэнэбат/-т даалгасугай:

1/Засгийн газрын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд тусгагдсан төсвийн зарим ерөнхийлөн захирагчийн нийт авлага, өр төлбөрийн хэмжээ нэмэгдсэнд дүгнэлт хийж, цаашид авлага, өр төлбөрийг бууруулах талаар арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

2/Засгийн газрын он дамжих үнэт цаасны хэмжээг тухайн жилийн төсвийн тухай хуульд тусгагдсан дүнгээс хэтрүүлэхгүйгээр зориулалтын дагуу зарцуулах.



2. Дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Ерөнхий аудитор /Д.Хүрэлбаатар/-т даалгасугай.

1/Засгийн газрын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар нийт хөрөнгийн дүн нэмэгдсэн шалтгааныг тодруулж, хөрөнгийн ангилал бүрээр тайлагнах;

2/Засгийн газрын богино хугацаат үнэт цаасны болон урт хугацаат өр төлбөрийн хэмжээ нэмэгдсэн шалтгааныг тодруулж, тайлагнах.

3. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо /Ч.Хүрэлбаатар/-нд, уг тогтоолын хэрэгжилтийн явцыг 2017 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор Төсвийн байнгын хороонд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /Ж.Эрдэнэбат/, Монгол Улсын Ерөнхий аудитор /Д.Хүрэлбаатар/ нарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2017 оны 07 дугаар
сарын 10-ны өдөр

Дугаар 54

Улаанбаатар
хот

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тангараг өргөх тов тогтоох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин хоёрдугаар зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Халтмаагийн Баттулгын Монгол Улсын Ерөнхийлөгчийн тангараг өргөх өдөр, цагийг 2017 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн 12 цаг 30 минутад байхаар тогтоосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц,
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 0.75

Индекс: 200003